



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/437

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тусгасан “Эрүүл мэндийн төвийн засвар (Хутаг-Өндөр сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Ланд-Арч” ХХК-тай 94,116,474 (ерэн дөрвөн сая нэг зуун арван зургаан мянга дөрвөн зуун далан дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Ланд-Арч” ХХК-ний захирал (Л.Отгонпүрэв)-д үүрэг болгосугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

4.Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 12-ны/ний өдрийн 127 дугаар
захирамжийн хавсралт

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
3	Магадлашгүй ажил	1 460 609	Ү.Бямбасүрэн
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	730 305	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	10 000 000	Ү.Бямбасүрэн
6	Нормчлолын сан	131 455	Ү.Бямбасүрэн
7	Захиалагчийн техник хяналтын зардал	1 460 609	Ү.Бямбасүрэн
8	Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 30 хоног	Ү.Бямбасүрэн